



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 14 өдөр

Дугаар А/57

Сүхбаатар сум

“Иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах, зарим үйл ажиллагааг түр хязгаарлах тухай” А/16 дугаар захирамжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 “а”, “б”, “ж”, “л”, 29.2, 29.3, 39 дүгээр зүйлийн 39.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5, Захиргааны ерөнхий хуулийн 22 дугаар зүйлийн 22.1, 63 дугаар зүйл, 70 дугаар зүйлийн 70.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10.4, 10.5, 10.6, 10.7, 10.8, Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.4, 4.5, 5 дугаар зүйлийн 5.3, Зөрчлийн тухай хуулийн 5.1.1, 5.1.2, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2020 оны “Засгийн газарт чиглэл өгөх тухай /шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай/” 10 дугаар зарлиг, Засгийн газрын 2020 оны “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай” 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн “Иргэдийн эрүүл мэндийн хамгааллыг сайжруулах, зарим үйл ажиллагааг түр хязгаарлах тухай” А/16 дугаар захирамжийн 1 дэх хэсэгт дараах нэмэлт, өөрчлөлт оруулсугай. Үүнд:

1.1.Захирамжийн 1.3 дах хэсэгт “...шинэ коронавирус /covid-19/-ийн халдвараас урьдчилан сэргийлэх, томуу, томуу тест өвчний өвчлөл, тархалтыг бууруулах зорилгоор 2020 оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдөр хүртэлх хугацаанд аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй бильярд, кино, үзвэр үйлчилгээний газар, амралтын газрууд, сүм, хийд, баар, кафе, караоке, паб, саун, нийтийн бүжиг, фитнес, теннис, соёл, спортын клубуудын үйл ажиллагааг түр зогсоосугай” гэж нэмж өөрчлөх;

1.2.Захирамжийн 1.4 дэх хэсэгт “...Хүнсний дэлгүүр, худалдааны төвүүдийн архи, согтууруулах ундаа худалдах цагийн хуваарийг өглөөний 10.00 цагаас оройн 18.00 цаг хүртэл, хүнсний дэлгүүрийн үйл ажиллагааг өглөөний 08.00 цагаас 22.00 цаг хүртэл ажиллахаар тогтоосугай” гэж өөрчлөх;

C:\users\albanbichig2020\zahiramj\A4.docx

430801153

2.Захирамжийн 1 дүгээр хэсэгт дараах заалтуудыг нэмсүгэй.Үүнд:


1.9."Улсын чанартай зам дагуу байршилтайгаас бусад нийтийн хоолны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдийн үйлчилгээний цагийн хуваарийг өглөөний 10.00 цагаас оройны 20.00 цаг хүртэл байхаар тогтоосугай”;

1.10.Зочид буудлын үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, аж ахуй нэгжүүдэд архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, худалдан борлуулахыг хориглож, үйлчлүүлэгчид гаднаас архи, согтууруулах ундаа нэвтрүүлэхгүй байхад хяналт тавьж ажиллахыг тухайн аж ахуй нэгжийн удирдлагуудад үүрэг болгосугай;

1.11.Худалдаа, үйлчилгээ, нийтийн хоолны газар, зочид буудал, амралтын газар, нийтийн орон сууцны орц, нийтийн эзэмшлийн зам, талбай гудамж, орчны болон айл өрхийн хог хаягдлыг түргэн шуурхай ачиж тухай бүр цэвэрлэж, ариутгал, халдваргүйжүүлэлтийн ажлыг тогтмол зохион байгуулж, “Эрүүл ахуйн тухай” хуулийн 14 дүгээр заалтыг хэрэгжилтийг хангаж ажиллахыг аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, тохижилт үйлчилгээний газрын удирдлагууд, сумдын Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж, хариуцлага тооцож ажиллахыг Мэргэжлийн хяналтын газарт тус тус даалгасугай;

1.12.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан иргэд, олон нийтэд мэдээлэх, холбогдох байгууллагуудад хүргүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга /Д.Ёндонжамц/, сумдын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ